



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №20


2019 оны 7 дугаар сарын 01-05

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 752 яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 99(13.2%) галзуугийн эрсдэлд өртсөн, 637(84.7%) хачигт халдвар, 5(0.6%) боом, 3(0.4%) тарваган тахал, 2(0.3%) хумхаа, 1(0.1%) ям, 2(0.3%) денги, 3(0.4%) бэтэг өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:



Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 99 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 30%-иар, эпидемиологийн 26 дугаар долоо хоногтой харьцуулахад 1 тохиолдлоор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: эзэнтэй нохойд (36.4%), чононд (19.2%), эзэнгүй нохойд (14.1%), үнэгэнд (9.1%), үхэрт (8.1%), мануулд (3.0%), мууранд (2.0%), тэмээнд (1.0%) нь уруулж, ноцуулж вакцин, ийлдэс эмчилгээнд хамрагдсан байна.

1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 116 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 637 сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 32.7%-иар, эпидемиологийн 26 дугаар долоо хоногтой харьцуулахад 37 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.




2019 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар ХР-ын 538 сэжигтэй тохиолдлын 100 (18.6%), ХБ-ын 48 сэжигтэй тохиолдлын 13 (27.1%), ХЭ-ын 51 сэжигтэй тохиолдол 5(9.8%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан байна.

1.3 Мэрэгч амьтны дуудлага:

2019 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийслэлийн 5 дүүргийн (БЗД, БГД, СХД, СБД, ЧД) хэмжээнд нийт 25 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

Тарваган тахлын дархлаажуулалт:

Улсын хэмжээнд тарваган тахлын дархлаажуулалтын хамралт 14.2 хувьтай байна.



Монгол улсад:

Галзуу өвчний мал, амьтны өвчлөл:

Архангай аймгийн Жаргалант сумын Зуслан багийн “Хувтийн дээд-Өвөлжөө” гэдэг газар малчин “Х”-ын 2 үхэр 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь тогтоогдсон байна. Тус сумын Засаг даргын захирамжаар 2019 оны 6 дугаар сарын 19-нд 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоож, голомтонд байгаа нийт 1536 малыг вакцинжуулсан байна.

Эх сурвалж: ОБЕГ

Мэрэгч амьтны дуудлага:

2019 оны 7 дугаар сарын 03-нд Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг “Шинэдаваа” гэдэг газар 1 удаагийн амьтны (тарвага) дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг Баян-Өлгий аймгийн ЗӨСТ-ийн лабораторид шинжилгээ хийгдэж байна.


Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ЗӨСТ

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ


Олон улсад:

Эбола вирус халдвар:

2019 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вирус халдварын сэжигтэй тохиолдол 2277 тохиолдол бүртгэгдсэнээс 1531(67%) нь нас барсан. Нийт тохиолдлын 1287 (57%) нь эмэгтэйчүүд, 633 (29%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзэлж байна.



Хүснэгт 1. Эпидемиологийн долоо хоногоор




Зураг 1. Эбола вирус халдварын тархалт, БНАК улс

Эх сурвалж: ДЭМБ

Галзуу өвчний мал, амьтны өвчлөл:

ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн мэдээгээр Испани улсын нэгэн тосгонд 2019 оны 6 дугаар сарын 17-нд RABV хэвшлийн вирусээр үүсгэгдсэн мал амьтны, галзуу өвчин бүртгэгдсэн. Нийт 150 нохой өртөмхий байснаас 1 нохой өвчилж үхсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

MERS-CoV-ийн халдвар:


2019 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн Саудын Араб улсын ЭМЯ-ны 26 дугаар долоо хоногийн эргэн мэдээллээр MERS-CoV-ийн халдварын сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдсэн. Ридах дүүрэгт амьдардаг 38 настай эрэгтэй, тэмээтэй хавьтал болсон өгүүлэмжгүй байна.



Эх сурвалж: Promed

Шувууны томуу өвчин:


Вьетнам улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 6 дугаар сарын 23-нд Таая Бен тосгонд шувууны томуугийн H5N6 вируст халдварын дэгдэлт бүртгэгдсэн байна. Нийт 1000 шувуу өртөмхий байснаас, 35 шувуу өвчилж үхэн, 965 шувууг устгасан тухай Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагад мэдээлсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Шүлхий өвчин:


Зимбабве улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 6 дугаар сарын 17-нд Матаведеланд Норт тосгонд SAT 1 хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчний дэгдэлт бүртгэгдсэн байна. Нийт 2133 үхэр өртөмхий байснаас 4 үхэр өвчилсөн тухай Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагад мэдээлсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Шувууны томуу өвчин:

БНХАУ-ын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 6 дугаар сарын 28-нд Юньлинь тосгонд шувууны томуугийн H5N2 вируст халдварын дэгдэлт бүртгэгдэж нийт 240 шувуу өвчилж үхэн, 18748 шувууг устгасан тухай Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагад мэдээлсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

Эх сурвалж	Хаана	Мэдээлсэн хугацаа	Өртсөн хугацаа	Нэгж	Өртөмхий	Өвчилж үхсэн	Устгасан
ДМАЭМБ	- Польш - Вармиан-Масуриан	2019.07.02	2019.06.24	Ферм	77 гахай	3	77 гахай
ДМАЭМБ	- Украин улс - Донецк муж	2019.07.02	2019.07.01	Ойд		2 гахай	4158 гахай
ДМАЭМБ	- ОХУ - Нижегород муж	2019.07.02	2019.07.01	Ойд		2 гахай	4 гахай
ДМАЭМБ	Камбожи	2019.07.03	2019.06.23	Ферм	586 гахай	6 гахай	

ЗӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгж